

ЭРДЭНЭ РЕСУРС 2026 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ҮР ДҮНГЭЭ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2026.08.14

2026 оны 2-р улирлын онцлох мэдээлэл:

- Баянхөндий алтны уурхай 11,709 унц алт олборлож, нэг унцыг дунджаар 4,493 ам.доллараар борлуулан, нийт 53 сая ам.долларын орлого бүрдүүлсэн.
- Баянхөндий уурхай 94%-ийн хүчин чадлаар ажиллан, алт авалт 96%-д хүрсэн нь төлөвлөсөн түвшнээс давсан үзүүлэлт юм.
- Зуун Мод молибден-зэсийн порфирийн төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулж байгаа бөгөөд үр дүнг 2026 оны 2-р хагаст танилцуулна.
- Оюу Толгой ордын ойролцоо байрлах Тэрэг Уул төслийн анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөрийг эцэслэн, 1.5 км хүдэржсэн структуын дагуу алт болон мөнгөний аномаль огтолсон.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN; OTCQX: ERDCF) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь 2026 оны 6-р сарын 30-нд дуусгавар болсон гурван болон зургаан сарын үйл ажиллагаа, санхүүгийн тайланг танилцуулж, Монголиан Майнинг Корпорэйшн ("MMC")-тэй хамтран эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ")-ийн хэрэгжүүлж буй Баянхөндий алтны уурхайн ("БХ") үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг хүргэхэд таатай байна. 2026 оны 2-р улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" эсвэл "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ"), Жилийн мэдээллийн маягт нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй хэсэг бөгөөд эдгээр нь SEDAR+ систем болон Компанийн цахим хуудсанд байршсан болно. Өөрөөр заагаагүй бол энэхүү мэдээнд дурдсан бүх мөнгөн дүнг мянган канад доллараар илэрхийлсэн.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Бид үйл ажиллагааны гүйцэтгэлээ үргэлжлүүлэн сайжруулж, Баянхөндий алтны уурхайгаас 11,709 унц алт олборлосон нь өмнөх улирлаас 37%-аар өссөн үзүүлэлт боллоо. Энэхүү өсөлтөд уурхайн олборлолтын гүйцэтгэл сайжирч, боловсруулах үйлдвэр тогтвортой үзүүлэлттэй ажилласан нь голлон нөлөөлөв. Хүдрийн хяналт болон уурхайгаас боловсруулах үйлдвэр хүртэлх үйл ажиллагааг оновчлон сайжруулснаар хүдрийн бохирдол, алдагдлыг бууруулж, боловсруулсан хүдрийн дундаж агуулга улирлын хугацаанд 25%-аар өслөө."

Тэрээр үргэлжлүүлэн, "Үүний зэрэгцээ, Эрдэнэ Ресурс нь Хөндий болон Оюу Толгой дүүрэгт байрлах, 100% эзэмшлийн үнэт болон суурь металлын төслүүдийн хайгуул, хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлж байна. Зуун Мод төслийн Анхан шатны эдийн засгийн тооцоолол ("PEA")-ыг боловсруулах ажлыг ахиулан, үр дүнг 2026 оны 2-р хагаст танилцуулахаар төлөвлөсөн. Мөн Хөвийн Хар талбайн зэсийн хэтийн

төлөвийг шалгах зорилгоор 2026 оны сүүлээр геофизикийн судалгаа болон өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэхээр төлөвлөсөн. Түүнчлэн, Оюу Толгой зэс-алтны системтэй залгаа орших Тэрэг Уул төслийн анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр Веб ("Web") талбайд 1.5 км урт трендийн дагуу аномаль алт, мөнгөний хүдэржилт огтолсон. Мөн гүний өрөмдлөгөөр байгалийн зэс болон аномаль алтны хүдэржилт огтолсон. Эдгээр үр дүнд үндэслэн бид тус төслийн эрхийн хугацааг дахин нэг жилээр сунгалаа."

2026 оны 2-р улирлын онцлох үйл явдлууд:



Баянхөндий алтны уурхай – 50% эзэмшил

- 2026 оны 2-р улиралд 11,709 унц алт, 3,317 унц мөнгө олборлож, борлуулсан.
 - Алтны олборлолт 2026 оны 1-р улиралтай харьцуулахад 37%-аар өссөн.
 - Алтыг нэг унц тутамд дунджаар \$4,493 ам.доллар, мөнгийг нэг унцыг нь \$72 ам.долларын дундаж үнээр борлуулж, нийт 53 сая ам.доллар (75 сая кан.доллар)-ын борлуулалтын орлого төвлөрүүлсэн.
 - Борлуулалтын нийт өртөг 24 сая ам.доллар (33 сая кан.доллар) байв.
- Баянхөндий алтны уурхай 2026 оны 2-р улиралд нийт 153 мянган тонн хүдэр буюу өдөрт дунджаар 1,682 тонн хүдэр боловсруулав.
 - Улирлын дундаж хүдрийн агуулга 2.4 г/т байсан нь 2026 оны 1-р улиралтай харьцуулахад 25%-аар өссөн үзүүлэлт юм.
 - Алт авалт 96%-д хүрч, төлөвлөсөн 93%-аас давсан үзүүлэлттэй байв.
- Эрдэнэ Монгол ХХК-ийн алтны төслүүдийн эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчлэн боловсруулав.

- Сүүлийн үеийн хайгуулын үр дүн болон алтны өнөөгийн үнийн түвшнийг тусган Баянхөндий, Хар Морь, Алтан Нар ордуудын эрдсийн нөөцийн тооцооллыг шинэчилсэн.
- Баянхөндий ордоос баруун зүгт орших Улаан ордын эрдсийн нөөцийн анхан шатны тооцооллыг боловсруулсан.
- Орон нутгийн хөгжил болон оролцогч талуудын хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.
 - Улирлын эцсийн байдлаар төслийн талбай дээр ажиллаж буй нийт ажилтнуудын 40 гаруй хувийг Баянхонгор аймгийн иргэд, Эрдэнэ Монголын нийт ажилтнуудын 13-ийг нь эмэгтэй ажилтнууд бүрдүүлж байна.
 - Шинэжинст сумын олон нийтийн арга хэмжээнд зориулсан нийтийн эзэмшлийн байгууламжуудыг шинэчлэх, өргөтгөх ажилд дэмжлэг үзүүлэв.
 - Төслийн үйлчилгээ болон байгаль орчны хөтөлбөрүүдийн хүрээнд орон нутгийн гэрээт гүйцэтгэгчидтэй хамтран ажиллаж байна.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул, хөгжүүлэлт

- Зуун Мод төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулж, 2026 оны 2-р хагаст эцэслэхээр төлөвлөж байна.
 - Уурхайн төлөвлөлт, маркетингийн судалгаа болон металлургийн туршилтын ажлуудыг гүйцэтгэсэн.
 - 2026 оны 3-р улиралд хэрэгжүүлэх гүний геофизикийн хайгуулын хөтөлбөрийн гэрээг байгуулсан.
- Оюу Толгой ордоос өмнө зүгт ойролцоогоор 10 км-т орших Тэрэг Уул төслийн талбайд нийт 2,710 метрийн 11 цооног өрөмдсөн.
 - Вэб (“Web”) талбайд 1.5 км урт эрдэсжсэн структурын дагуу найман гүехэн цооног өрөмдөж, аномаль алтны хүдэржилт огтолсон (0.1 г/т-оос 1 г/т хүртэл алт, 15 г/т хүртэл мөнгөний агуулга бүхий интервал огтолсон).
 - Гүний геофизикийн зорилтот хэсгийг шалгах өрөмдлөгөөр газрын гадаргаас 150 метрийн дотор нүүрсний үе болон байгалийн зэсийн ул мөр огтолсон.
 - 2026 оны 7 сард 400,000 ам.долларын опционы төлбөр төлж, Тэрэг Уул төслийн эрхийн гэрээний хугацааг сунгасан.

Компанийн тухай

- 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 9,993 долларын цэвэр орлоготой ажилласан бол 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 4,122 долларын цэвэр алдагдалтай байв.
 - Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн зөвшөөрсөн орлого буюу ЭМ ХХК-ийн орлогын Компанид ногдох хувь нь 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд 11,201 доллар байсан бол 2025 оны мөн үед 2,995 долларын алдагдал бүртгэсэн. Энэхүү өөрчлөлт нь тайлант улиралд Баянхөндий уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотой бөгөөд өмнөх оны мөн үед уурхай нь бүтээн байгуулалтын шатанд байсан.

- 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хайгуул, үнэлгээний зардал 726 доллар байсан бол 2025 оны мөн үед 514 доллар байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн энэхүү зардал нь 2025 оны 7 сард байгуулсан гэрээний хүрээнд Тэрэг Уул төсөлд хайгуулын хөтөлбөр гүйцэтгэсэнтэй холбоотой.
- 2026 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын компанийн болон захиргааны зардал 1,617 доллар байсан бол 2025 оны мөн үед 1,488 доллар байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гарсан өөрчлөлт нь хөрөнгө оруулагчидтай харилцах, мэргэжлийн үйлчилгээний төлбөр болон зохицуулагч байгууллагатай холбоотой зардлууд өссөнтэй холбоотой.
- 2026 оны 6 сарын 30-наас хувьцаагаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.
 - Хөтөлбөрийн хүрээнд Компани эргэлтэд буй энгийн хувьцаанаас 4,900,000 хүртэлх ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох боломжтой ба энэ нь эргэлтэд буй энгийн хувьцааны ойролцоогоор 10%-тай тэнцэнэ.
 - Өнөөг хүртэл дунджаар \$5.21 доллартай тэнцэх 94,400 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгосон.

Үр дүнгийн тайлангийн хурал

Компанийн удирдлага 2026 оны 8 сарын 17-ны өдрийн өглөөний 10:00 цагт (Зүүн эргийн цаг, EST) вебкаст зохион байгуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг танилцуулна. Оролцохыг хүсвэл дараах холбоосоор бүртгүүлнэ үү: [ВЕБКАСТ](#)

Вебкастын бичлэгийг уг холбоосоор нэг жилийн хугацаанд үзэх боломжтой. Утсаар холбогдон оролцох бол:

- Хойд Америк – төлбөргүй дугаар: (+1) 800 717 1738
- Олон улсын дугаар: (+1) 289 514 5100

Мэргэшсэн этгээд

Компанийн Өсөлт хөгжил хариуцсан захирал Жон Лёнс (FAusIMM) нь Ашигт малтмалын төслийн мэдээлэл тайлагналын стандарт (NI 43-101)-д заасан “Мэргэшсэн этгээд” бөгөөд хэвлэлийн мэдээнд багтсан Баянхөндий уурхайн үйл ажиллагааны мэдээллийг компанийн өмнөөс хянан, баталгаажуулсан болно.

Компанийн ахлах геологич Петер Далтон (Нова Скошиа муж) нь Ашигт малтмалын төслийн мэдээлэл тайлагналын стандарт (NI 43-101)-д заасан “Мэргэшсэн этгээд” бөгөөд хэвлэлийн мэдээнд багтсан хайгуултай холбоотой техникийн мэдээллийг компанийн өмнөөс хянан, баталгаажуулсан болно.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсын хязгаарлагдмал хайгуул хийгдсэн бүс нутагт өндөр агуулга бүхий Баянхөндий алтны уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй уул уурхайн компани юм. Компани нь Хөндий Эрдсийн Дүүрэгт Баянхөндий алтны төслийн орчимд хэд хэдэн үнэт болон суурь металлын төслүүдийн хувь эзэмшдэг. Эрдэнэ Ресурс Девелопмент

Корпораци нь Торонто (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржүүд (MSE:ERDN) ба OTCQX зах зээлд (OTCQX:ERDCF) бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал байж болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн эх хувилбараас орчуулагдсан болно. Англи, монгол хувилбарын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
И-мэйл: info@erdene.com
Twitter: <https://twitter.com/ErdeneRes>
Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>
LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>